Г.БАТМӨНХ
2025 оны ..... сарын ..... өдөр

ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

1. Ажлын нэр:	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүдэр олборлолт, баяжуулалтын технологийн үзүүлэлтийг тодорхойлох, сорьцлолтын хөндлөнгийн хяналт шинжилгээ
2. Ажил хийх үндэслэл:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/205 тушаалын хавсралт Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын 5.2 дугаар зүйл.
3. Ажлын байршил:	Геологи маркшейдерийн хэлтэс (ГМХ) Ил уурхай (ИУ) Баяжуулах үйлдвэр (БҮ) Судалгаа шинжилгээний хүрээлэн (СШХ)
4. Ажлын зорилго:	Баяжуулах үйлдвэрт боловсруулж буй хүдрийн технологийн шинж чанарыг тодотгох, хүдэр бэлтгэл, флотацийн дамжлагын бүтээгдэхүүнүүдэд сорьцлолт хийж технологийн баланс тооцон, ширхэг, элемент, эрдсийн дэлгэрэнгүй шинжилгээг гүйцэтгэн цаашид баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангахад зөвлөмж өгч дүгнэлт гаргах.
5. Хийгдэх ажлууд:	Хяналт шинжилгээний ажлын тайлан дараах агуулгын хүрээнд хийгдсэн байна. Үүнд: 1. Ордын талаарх мэдээлэл 2. Технологийн аудит 3. Лабораторийн туршилт 4. Харьцуулсан дүн шинжилгээ 5. Дүгнэлт 6. Зөвлөмж Дараах шинжилгээ, судалгаа, тооцооны ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд: - Хүдэр бэлтгэлийн бүтээгдэхүүний ширхэг, металлын болон эрдсийн тархалтын шинжилгээ - Флотацийн баяжуулалтын бүх технологийн хэлхээний схемийн дагуу сорьцлолт гүйцэтгэн бүтээгдэхүүнүүдэд бүх төрлийн шинжилгээ - Технологийн балансын бүтээгдэхүүнүүдэд эрдсийн болон петрографийн судалгаа, эрдсийн бүрдэл, сулрал, хам ургалын талаарх тоон шинжилгээ хийх, - Хүдэрт – Cu, Mo, Fe, S, Ag, Au, As, Pb, F, P. - Зэсийн баяжмалд - Cu, Mo, Fe, S, Ag, Au, As, Pb, F, P. - Молибдены баяжмалд - Cu, Mo, Fe, S, Re, Ag, Au, As, Pb, F, P тодорхойлох - Сорьцлолт хийсэн үр дүнгээр Баяжуулах үйлдвэрийн технологийн балансын тооцоог олон улсад жишиг болсон стандартын дагуу гүйцэтгэх (үүнд хэмжилт, шинжилгээний алдааг үнэлэн тооцох), - Баяжуулах үйлдвэрийн баяжуулалтын дамжлагын балансын бүтээгдэхүүнүүдэд хийсэн хэмжилтүүдэд статистик шинжилгээ хийх (2025 оны)

	Ажлын явцад бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь чанартай гаргахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхэд дараах үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд: - Ажил гүйцэтгэхэд шаардлагатай нууцын зэрэглэлээс бусад мэдээллээр хангана; - Технологийн цэгүүдэд сорьцлолт хийх нөхцөл бололцоогоор хангана - Ажлын үйл явцад санал, зөвлөмж өгч, чанартай бүтээгдэхүүн гаргахад хамтран ажиллана.
6. Ажлын аргачлал:	- Технологийн эрдсийн шинжилгээнд үндэслэн процессыг ордын ТЭЗҮ-д заагдсан гол үзүүлэлттэй харьцуулан дүгнэнэ. - Баяжуулах үйлдвэрийн технологийн түвшинг үнэлэхдээ нэг бүтэн ээлжийн турш тодорхой хугацааны мөчлөгтэй дээжлэлт хийж тухайн хугацаанд боловсруулсан хүдэр, гарсан баяжмал, хаягдлын гарц, хэмжээ ($м^3$/цаг, тн/цаг), шат дамжлага бүр дэх процессын хугацааг тодорхойлон сорьцлолтын бүтээгдэхүүнд агуулагдах ашигт эрдсийн агуулгаар технологийн процессыг дүгнэнэ. - Баяжуулах үйлдвэрийн баяжмал нь Монгол улсын зэсийн баяжмал болон молибдены баяжмалын чанарын стандарт шаардлага хангаж буй эсэхийг тогтооно. - Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйн хяналтын цооногуудад дээжлэлт хийж, химийн бодис, хүнд металлын агуулга Монгол улсын стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байгаа эсэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй эсэхэд дүгнэлт өгнө.
7. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	- Хяналт, сорьцлолтын ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай байх
8. Бүтээгдэхүүн:	- Хяналт шинжилгээний хэвлэмэл монгол хэл дээрх 3 хувь тайлан, олон улсад итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу бүхий хавсралт, болон тэдгээрийн цахим хэлбэрийн хамт хүлээлгэн өгнө.

Танилцаж хянасан: